

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2. Сонгогдсон гишүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч “Академич” хэргэм олгоно.”

2/5 дугаар зүйлийн 5.3.6 дахь заалт:

“5.3.6 Академийн Ерөнхийлөгч нэг удаа улиран сонгогдож болно.”

3/5 дугаар зүйлийн 5.5.3 дахь заалт:

“5.5.3. Бага чуулганы гишүүнийг сонгох;”

4/7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт:

“7.1.3. Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд томоохон төсөл хөтөлбөрүүдэд хараат бус хянан магадлагаа хийх;”

2 дугаар зүйл. Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэрийн “Шинжлэх ухааны” гэсний өмнө “Монгол Улсын”, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “...хөгжүүлэх” гэсний дараа “судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх”, “...дэлгэрүүлэх” гэсний дараа “нийгмийг соён гэгээрүүлэх”, “...бүхий” гэсний дараа “улсын төсвөөс санхүүждэг” гэж, мөн зүйлийн 2.2 дахь хэсгийн “Академи нь” гэсний дараа “шинжлэх ухааны үндсэн чиглэлүүдээр бүтцийн академи, салбарын бага чуулгантай байна. Тэдгээрийн нэр, байгуулах шинжлэх ухааны чиглэл, гишүүдийн тоог Тэргүүлэгчид тогтооно. Бүтцийн академи нь салбарын бага чуулганы чиг үүрэгтэй байна”, 4 дүгээр зүйлийн 4.1. дэх хэсгийн “шинжилгээний” гэсний дараа “байгууллага” гэж, “...бусад” гэсний дараа “нэгжтэй” гэж, мөн зүйлийн 4.2. дахь хэсгийн “...угсаатны зүй,” гэсний дараа “археологи, палеонтологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг музейг” гэж, 5 дугаар зүйлийн 5.3.1. дэх заалтын “...бодлого,” гэсний дараа “судалгаа хөгжүүлэлтийн ажлын” гэж, мөн зүйлийн 5.3.5. дахь заалтын “академийн” гэсний өмнө “эрдэм шинжилгээний ажил идэвхтэй хийж байгаа академийн гишүүдээс нэр дэвшүүлж” гэж, “...дэд ерөнхийлөгч” гэсний дараа “эрдэмтэн нарийн бичгийн дарга, тэргүүлэгчдийг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсгийн “...түүний” гэсний дараа “чиг үүргийг” гэж, “тэргүүлэгчид” гэсний дараа “хэрэгжүүлнэ” гэж, 7 дугаар зүйлийн 7.4.2. дахь заалтын

“...хэвлэж нийтлэх,” гэсний дараа “шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэтгүүл гаргах” гэж, мөн зүйлийн 7.5. дахь хэсгийн “...хийсэн” гэсний дараа “бэлгэдэлтэй” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “шинжлэх ухаан” гэсний өмнө “Монгол Улсын хөгжлийн бодлого” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалтын “...үр дүнг шүүн хэлэлцэх” гэснийг “үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “удирдана” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “хэлэлцсэн” гэснийг “хэлэлцэх”, 9 дүгээр зүйлийн 9.1.2. дахь заалтын “...удирдах” гэснийг “удирдлагын” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. 4 дүгээр зүйлийн 4.1. дэх хэсгийн “хүрээлэн, төв, лаборатори” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Академи нь шинжлэх ухааны салбараар Бага чуулган /цаашид “Бага чуулган” гэх/-тай байж болно.” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “өдөр тутмын үйл ажиллагааг” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааг боловсронгуй болгох,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ